



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 03

Сүхбаатар сум

Эх, хүүхдэд үзүүлэх тусламжийн чанарыг сайжруулж,
эндэгдлээс сэргийлэх тухай

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 56 дугаар тогтоолын явцын тайлан, үр дүн, тулгамдаж буй асуудлын талаар Эрүүл мэндийн газрын дарга Ж.Одын сонсголыг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Эхийн эндэгдэл 2018, 2019 онуудад тус бүр 1 тохиолдол бүртгэгдэж, жирэмсний эрт үеийн хяналт улс, аймгийн дунджаас доогуур, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл улс, аймгийн дунджаас доогуур байгаа хэдий ч тогтвортой буурахгүй, амьгүй төрөлт нэмэгдэх хандлагатай байгаад дүгнэлт хийж, сумдын Засаг дарга, аж ахуй нэгж байгууллага, иргэдийн үүрэг оролцоог нэмэгдүүлж тодорхой үр нөлөөтэй ажлыг зохион байгуулах шаардлагатай байгааг харгалзан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр батлах тухай” 78 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д ДААЛГАХ нь:

1.Эх, хүүхдийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эрчимт эмчилгээний багаж тоног төхөөрөмж, фото аппаратаар үе шаттай хангах;

2.Эх, хүүхдийн чиглэлээр ажилладаг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлэх;

3.“Эх, хүүхдэд ээлтэй сум” аяныг өрнүүлэх, үр дүнг тооцож, урамшуулах;

Хоёр. Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д ДААЛГАХ нь:

1.Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн нэрийн хяналтыг нэвтрүүлж, жирэмсний эрт үеийн хяналтыг нэмэгдүүлэх алслагдсан сумдын хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах;

2.Элэгний В вирусын халдвартай эхээс төрсөн хүүхдэд иммуноглобулин хийж, вирусын халдварыг бууруулах ажлыг эхлүүлж, үе шаттай хэрэгжүүлэх;

3.Эх, хүүхдийн чиглэлээр ажилладаг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг төрөлжсөн эмнэлгүүдэд туршлага судлуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдалтыг нэмэгдүүлэх;


Гурав. Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

1.Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийг нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангаж, эх хүүхдэд ээлтэй орчин нөхцлийг бүрдүүлэх;

2.Хүн амын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулан, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, 0-5 хүртлэх насны хүүхдийн гэрийн эргэлтийн бүртгэл хөтлөлт, өсөлт хөгжилтийн үнэлгээнд хяналт тавих;

3.Сум орон нутгийн хэмжээнд төрсөн болон шинээр хяналтанд орсон жирэмсэн эхчүүд, эмэгтэйчүүдийн судалгаа, мэдээлэлд тогтмол хяналт тавьж, аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэн жирэмсний эрт үеийн хяналтыг сайжруулах;

4.Эмзэг эрсдэлт бүлгийн жирэмсэн эмэгтэй, төрсөн эх, 5 хүртэлх насны хүүхдэд эмнэлгийн нэн шаардлагатай тусламж үзүүлэхэд шаардагдах унаа, онгоцны зардлыг олгоход дэмжлэг үзүүлэх;

ДАРГА  Г.БЯМБАА

